

## ЕБС-ИЙН СУРАЛЦАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*/8-р анги удирдсан багш нарт зориулсан сургалтын модуль/*

*Г. Нарангэрэл*

*/Нийслэлийн лаборатори 20 дугаар сургуулийн сургалтын менежер/  
gnarangerel2005@gmail.com*

### **Модулийн зорилго:**

БШУ-ны сайдын 2021 оны А/199 тоот тушаалаар батлагдсан “ЕБС-ийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр” –ийн “Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих” 7 дугаар зорилтын хүрээнд “суралцагчдад суралцах чиглэл, мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх”-ээр заасныг үндэслэн 8 дугаар анги удирдсан багш нарт хичээлээс гадуурх ажлын хүрээнд суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулахад нь арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү модулийг боловсруулав.

### **Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:**

Суралцагчид дор хаяж дараах 5 гол шилжилттэй нүүр тулдаг. Үүнд:

- Хүүхэд наснаас өсвөр нас түүнээс насанд хүрэхтэй холбоотой гарах шилжилт;
- Бага ангиас дунд анги, түүнээс ахлах ангид орох шилжилт;
- Сургууль төгсөөд их дээд сургууль эсвэл мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцах, түүнээсээ ажил хөдөлмөр эрхлэх шилжилт;
- Хөдөлмөрийн зах зээл дотор гардаг өөрчлөлт;
- Нийгэмд тогтмол явагддаг өөрчлөлт, тухайлбал глобалчлал болон техник технологийн нөлөөгөөр гарч байгаа өөрчлөлт шилжилтүүдийг энд дурьдаж болно.

Энэ эмх замбараагүй өөрчлөлттэй зэрэгцүүлээд суралцагчид өөрийгөө таньж мэдэх, ойлгох, ажил хөдөлмөрийн ертөнцийн талаар мэдэх, богино, урт хугацааны ухаалаг сонголт хийх зэрэг хэрэгцээ шаардлагуудтай нүүр тулж байна.<sup>1</sup> Иймд ерөнхий боловсролын сургуулийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны гол үүрэг нь *суралцагчдад дээр дурдсан шилжилтүүдээ удирдах, суралцах чиглэл, ажил мэргэжилтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах, оновчтойгоор үйл хэрэг болгон хэрэгжүүлэхэд нь* дэмжиж туслахад оршино. 8 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд анги удирдсан багш танд дараах зүйлүүдийг анхаарч ажиллахыг зөвлөж байна:

- ✓ АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд 2016,2018 онуудад боловсруулан гаргасан гарын авлагуудаас ажил мэргэжлийн хөгжлийн онол, үзэл баримтлал, үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулгын хүрээ, анги бүрд суралцагчдад эзэмшүүлэх чадвар, хэрэгжүүлэх арга зүйн талаар уншиж судлан, үр дүнтэй хэрэглэх;
- ✓ 8 дугаар ангийн хүүхдүүдэд ажил мэргэжлийн ертөнцөд ямар мэргэжил, ажлын байр байж болох, ирээдүйн ажил мэргэжилтэй холбоотой өөрийгөө бага мэддэг, хөдөлмөрийн зах зээл, сургалтын боломжуудын талаарх мэдлэг, ойлголт дутмаг, ажил мэргэжлийн сонголт хийхдээ бусдын нөлөөнд амархан автах, сонголтоо хийсэн ч түүндээ хүрэх төлөвлөгөөгөө яаж хийхээ сайн мэддэггүй зэрэг асуудлууд байдаг.

Иймд сургалт, ажил мэргэжилтэй холбоотой тэдэнд тулгардаг асуудлаа таньж мэдэх, энэ асуудлаа шийдэхэд нь суралцагчдад дэмжлэг үзүүлэхэд чиглүүлж, 8 дугаар ангийн суралцагчдын нас сэтгэхүй, хөгжлийн онцлогийг харгалзан ажил мэргэжлийн чиг баримжаа

<sup>1</sup> БСШУЯ, АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” –“Багшийн гарын авлага”, УБ, 2016

олгох үйл ажиллагааг оновчтой төлөвлөж, танхимын болон танхимын бус аргыг хослуулан үр дүнтэй зохион байгуулах;


- ✓ Суралцагч бүр нийгмийн, сэтгэл хөдлөлийн болон биеийн хөгжлийн хурдаараа, ажлын ертөнц болон сургалтын талаарх үзэл бодлын төлөвлөөрөө, өөрийн сонирхол, ур чадварын талаар ойлгох, ирээдүйгээ төсөөлөх, төлөвлөх чадамжаараа ялгаатай байдгийг санаж, өөрийгөө авьяас сонирхол, ур чадвараа сонирхсон ажил мэргэжилтэйгээ холбох, суралцах чиглэл, ажил мэргэжлийн төлөвлөгөө хийх, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх;
- ✓ Суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны тулгуур асуудлын нэг нь ажил мэргэжил, сургалтын талаар чанартай, бодитой, шинэлэг мэдээлэл байдаг. Ялангуяа, ЕБС-ийн 8, 9 дүгээр ангийн суралцагчдад чиглэсэн мэдээлэл нэлээд бага байдаг. Ажил мэргэжил, суралцах чиглэлийн талаар суралцагчдын дунд олон янзын төөрөгдөл гарахаас сэргийлж, анги удирдсан багш ажил мэргэжил, сургалтын талаар шинэлэг, үнэн бодит мэдээлэл цуглуулах, түүнийгээ үр дүнтэйгээр ашиглах;
- ✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эцэг эх, асран хамгаалагч, бусад багш, сургуулийн удирдлагатай хамтран ажиллах;
- ✓ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаагаар суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар нь тэднийг амьдралын сонголт, чиглэлээ удирдан залахад хэрэглэгдэх насан туршийн мэдлэг, чадвар байх тул энэхүү үйл ажиллагааг тасралтгүй явагдах үйл явц гэж үзэн тогтвортой хэрэгжүүлэх.

#### **Агуулга хэрэгжүүлэх сургалтын цагчилсан төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зүй**

Дунд ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийг “ойлголт”, “үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх” гэсэн 2 агуулгын хүрээнд хэрэгжүүлэх /Зураг 1/ бөгөөд “Ойлголт” агуулга нь *өөрийгөө ойлгох, ажлын ертөнцийн талаар ойлгох* болон суралцах чиглэл, ажил мэргэжилтэй холбоотой сонголт хийх, шийдвэр гаргахад *нөлөөлөх хүчин зүйлийн талаар ойлгох* гэсэн 3 үйл ажиллагааг багтаана.

“Үйл хэрэг болгох, хэрэгжүүлэх” агуулга нь *зорилгоо дэвшүүлэх, шийдвэр гаргах үйл хэрэг болгох болон эдгээрийг эргэн харж дүгнэх* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэнэ.

*Зураг 1 . Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулга*



Эдгээр үйл ажиллагаанаас 8 дугаар ангид **өөрийгөө таньж мэдэх, ажлын ертөнцийг таньж мэдэх, нөлөөллийг ойлгох, суралцах чиглэл, ажил мэргэжлийн зорилгоо дэвшүүлж, төлөвлөгөө гаргах** чадварыг эзэмшүүлэхэд голчлон анхаарч, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаагааны төлөвлөгөө гарган зохион байгуулна. Төлөвлөгөөг нийт 8 дугаар ангийн багш нар хамтран сургуулийнхаа онцлогт нийцүүлж, сургуулийн хөтөлбөрийн нэг хэсэг болгон хичээлээс гадуурх бусад үйл ажиллагаатай уялдаатайгаар боловсруулан хэрэгжүүлбэл үр дүнтэй.

2016 онд “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” –өөс багш, сургуулийн удирдлагад зориулан гаргасан гарын авлагыг ашиглан боловсруулсан 8 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны төлөвлөгөөний загвартай танилцаж, өөрсдийн онцлогт тохируулан баяжуулан ашиглаарай.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь суралцагчдыг өөрийн сурах үйл ажиллагаа, хүсэл тэмүүлэл, зорилгоо дээд зэргээр ашиглах боломжийг олгоход чиглэсэн байх ёстой тул багш зөвхөн мэдээлэл өгөөд зогсохгүй, сургалт, үйл ажиллагаагаа багаар болон хосоор ажиллахаар танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулж, сургалтын идэвхтэй аргуудыг бүтээлчээр, үр дүнтэй хэрэглэх нь зүйтэй.

8 дугаар ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэлбэр :

- **Сургалт** : танхимаар болон цахимаар ажил мэргэжил, өөрийгөө таньж мэдэх, ажил мэргэжилтэй холбоотой мэдээлэл өгөх, даалгавар ажиллуулах зэргээр хичээл заах
- **Туршлага судлах**: янз бүрийн ажил мэргэжилтэй хүмүүсээс ярилцлага авах, зочин урьж туршлагы нь яриулах, ажлын байранд зочлох гэх мэт.

Анги танхимын сургалтад ашиглах арга зүй:	Туршлага судлахад ашиглах арга зүй:
<ul style="list-style-type: none"> <li>• Оюуны зураглал</li> <li>• Тархины шуурга</li> <li>• Венийн диаграмм</li> <li>• Мэдээлэл, танилцуулга хийх</li> <li>• Хэлэлцүүлэг хийх</li> <li>• Бичвэртэй ажиллах</li> <li>• Хэсэгчилсэн эрэл хайгуул хийх</li> <li>• Асуудал дэвшүүлэн тайлбар хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ярилцлага авах</li> <li>• Ажлын байранд ажиглалт хийн тэмдэглэл хөтлөх</li> <li>• Асуулга авах</li> <li>• Жишээн дээр суралцах</li> <li>• Аялал</li> </ul>

### **8 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны төлөвлөгөө /загвар/**

**Зорилго:** Суралцагчдыг ажлын ертөнцтэй танилцуулан, өөрийн сонирхол, ур чадварыг таньж мэдэх, суралцах чиглэл, ажил мэргэжлийн зорилгоо тодорхойлж, төлөвлөгөө гаргаж сурахад нь дэмжлэг үзүүлэх

**Хүрэх үр дүн:**

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд хамрагдсанаар суралцагчид дараах мэдлэг, чадвартай болно:

Мэдлэг:

o Өөрийн онцлог шинж чанарыг ажил мэргэжилтэй уялдуулах талаарх мэдлэгтэй болсон байна.

o Ажлын ертөнц болон сургалтын боломжуудын талаарх мэдлэг, ойлголттой болсон байна.

o Ажил мэргэжлийн сонголт хийхэд нөлөөлөх хүчин зүйлүүдийн талаар мэддэг болсон байна.

Чадвар:

o Өөрийгөө илэрхийлж, ур чадвар, сул талаа хөгжүүлэх чадвартай болох

o Сургалтын болон ажил мэргэжлийн зорилгоо тодорхойлох, төлөвлөх чадвартай болох

**Хугацаа:** 2021-2022 оны хичээлийн жил

Чиглэл	Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Ашиглах ном гарын авлага
Сургалт Танхимаар цахимаар	1	Хэлэлцүүлэг Ажил мэргэжил гэж юу вэ?	4-р долоо хоног	Багшийн гарын авлага, 2016 он
	2	Дасгал 1. Богино зохион бичлэг	5-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 85
	3	Дасгал 2. Дуртай зүйлээ тодорхойлох	6-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 89
	4	Дасгал 3. Дүрд тоглох	7-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 85
	5	Дасгал 4. Ажлын орчин	8-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 89
Бие даан гүйцэтгэх даалгавар	6	Ажил мэргэжлийн мэдээлэл цуглуулах Сургуульд ямар мэргэжилтэй хүн ямар ажил хийж байгаа талаар бие даан судалгаа хийх	9-р долоо хоног	
	7	Суралцагчид багаараа ангийн буланд ажил мэргэжлийн талаар мэдээлэл бэлтгэн байршуулж, мэдээллээ хуваалцах	10-р долоо хоног	Ажил мэргэжилтэй холбоотой ном гарын авлага Ажил мэргэжилтэй холбоотой вэбсайт
<b>2-Р УЛИРАЛ</b>				
Сургалт Танхимаар эсвэл цахимаар	1	Дасгал 1. Шивнээ буюу цуу яриа	1-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 86
	2	Дасгал 2. Генограм	2-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 90
	3	Дасгал 3. Амьдралын мөчлөгийн хуваарь	3-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 86
	4	Дасгал 4. Ухаалаг	4-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 90
	5	Дасгал 5. Өдрийн тэмдэглэл	5-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 87
	6	Дасгал 6. Ажил, мэргэжлийн төлөвлөгөө боловсруулах	6-р долоо хоног	Сурагчийн ажил мэргэжлийн төлөвлөгөө 8 дугаар анги
Туршлага судлах	7	Ажлын байранд зочлох	7-р долоо хоног	
	8	Сонголтод нөлөөлсөн хүчин зүйлийн судалгаа Гэр бүлийн гишүүдийн , ажил мэргэжлийг судлан яагаад тухайн мэргэжлийг сонгосон, сонголт хийхэд нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулна.	8-р долоо хоног	
Турш лага судл	1	Дасгал 1. 12-р анги Ажлын ярилцлага хийхэд бэлтгэх	1-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 87

	2	Сургуулийн ажилтныг зочноор урьж ажил мэргэжлийнх нь талаар ярилцлага хийх - Ажил мэргэжлээ сонгоход хамгийн их нөлөөлөлсөн хүн хэн байсан - Энэ мэргэжлийг эзэмшихийн тулд ямар сургуульд хэдэн жил суралцсан - Ямар хичээлээр шалгалт өгсөн - Эзэмшсэн мэргэжлээрээ ажил хийхэд ямар ур чадвар илүү хэрэгтэй байдаг - Ажил дээрээ ямар үүрэг хариуцлага хүлээдэг, - цалин хөлс ямар байдаг талаар асуун ярилцана.	2-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 92
	3	Дасгал 2.Эргэж харж, дүгнэх Бага, 8-р анги	3-р долоо хоног	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 88, 92
	4	Ажил мэргэжлийн талаарх суралцагчдын мэдлэг, ойлголтыг үнэлж дүгнэх “Миний мэргэжил-миний сонголт” зохион бичлэг	4-р долоо хоног	

### Модулаар 8 дугаар ангийн суралцагчдын эзэмших мэдлэг чадвар, үнэлгээ

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” –ийн хүрээнд 2016 онд гаргасан “Багшийн гарын авлага” номд 8 дугаар ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын сургалтаар хийж гүйцэтгэх 14 цагийн дасгал даалгаврыг санал болгосон ба эдгээр дасгал, даалгаврыг хийснээр суралцагчид дараах мэдлэг чадвартай болно.

*Хүснэгт 1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ойлголт” агуулгын хүрээнд 8 дугаар ангийн суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар*

Үйл ажиллагаа	Дасгал даалгавар	Суралцагчийн эзэмших мэдлэг	Суралцагчийн эзэмших чадвар
Ерөнхий ойлголт	Ажил мэргэжил гэж юу вэ?	“Ажил”, “мэргэжил” гэсэн нэр томъёоны ялгааг таньж мэднэ.	Ажил мэргэжлийн талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлж сурна.
Өөрийгөө таньж мэдэх, ойлгох	Богино зохион бичлэг	Ажил мэргэжил, сургалттай холбоотойгоор өөрийгөө таньж мэдэх, түүнийгээ хөгжүүлэх талаар мэдлэг ойлголттой болох	Өөрийн сонирхол, чадвар, арга барил, давуу тал болон чадамж юу болохыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт гаргаж сурна.
	Дуртай зүйлээ тодорхойлох		
Ажлын ертөнцийг таньж мэдэх	Дүрд тоглох	Нэг байгууллагад олон төрлийн ажил, мэргэжилтэй хүмүүс хамтран ажилладаг бөгөөд тэд	Өөрсдийн сайн мэддэг орчинд байдаг ажил хөдөлмөрийн төрлүүдийг тодорхойлж сурна.

	Ажлын орчин судлах	өөр өөрийн үүрэг хариуцлагатай байдаг талаар ойлголттой болно. Хөдөлмөрийн салбарын талаар ойлголттой болно.	Тодорхой нэг үйл явдалтай холбоотой ажил хөдөлмөрийг тодорхойлж сурна. Өөрийн сонирхож буй ажил мэргэжил хөдөлмөрийн ямар салбарт багтдагийг тодорхойлж сурна. Ажил мэргэжлийн талаар мэдээлэл цуглуулж сурна.
Нөлөөллийг ойлгох	Шивнээ буюу цуу яриа	Ажил мэргэжлийн сонголт хийхэд хэн, юу нөлөөлдөг, тухайлбал цуу яриа, мэдээ мэдээлэл, гэр бүлийн уламжлал гэх мэт хүчин зүйлийн нөлөөллийн талаар ойлголттой болно.	Ажил мэргэжилтэй холбоотой мэдээллийн эх сурвалжийг судалж, мэдээллийн үнэн зөв эсэхийг тогтоож сурна.
	Генограм	Ажил мэргэжлийн сонголт хийхэд хэн, юу нөлөөлдөг, тухайлбал цуу яриа, мэдээ мэдээлэл, гэр бүлийн уламжлал гэх мэт хүчин зүйлийн нөлөөллийн талаар ойлголттой болно.	Өөрийн гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжилд нийтлэг онцлог шинж байгаа эсэхийг тодорхойлж, ийм сонголт хийхэд нөлөөлсөн хүчин зүйлийг судлах

*Хүснэгт 2. . Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн “Үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх” агуулгын хүрээнд 8 дугаар ангийн суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар*

Үйл ажиллагаа	Дасгал даалгавар	Суралцагчийн эзэмших мэдлэг	Суралцагчийн эзэмших чадвар
Зорилгоо тодорхойлох	Амьдралын мөчлөгийн хуваарь	Өөрсдийн өнгөрсөн болон ирээдүйн ажил, амьдралын талаар урт хугацааны мөчлөгт хуваарь хэрхэн хийх талаар ойлголттой болно.	Өөрийн сонирхол, хүсэл эрмэлзэл, амжилтын дагуу суралцах чиглэл, зорилгоо тодорхойлж сурна.
	Ухаалаг	Ажил мэргэжлийн зорилгоо төлөвлөх нь ямар ач холбогдолтой байх талаар ойлголттой болно.	Өөрийнхөө зарим нэг чанарын талаар эргэцүүлэн бодож, хичээл сурлага, биеийн хөгжил, болон нийгмийн талаас сайжруулах эсвэл хөгжүүлэх шаардлагатай зүйлүүдийг тодорхойлж, өөрийнхөө сурлагын амжилт, ур чадвар, зан чанарыг сайжруулах ухаалаг зорилго дэвшүүлж сурна.
Сонголт хийх, шийдвэр гаргах	Өдрийн тэмдэглэл	Өдөр тутамд хийдэг үйл ажиллагааны зарим нь суралцагчдын өөрсдийн сонголт байдаг, энэ сонголт нь хүн бүрт өөр өөр байдаг талаар ойлголттой болно. Ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргах ойлголттой болно.	9 дүгээр ангидаа илүү сайн судлах ажил мэргэжил, амжилтаа ахиулах хичээлээ сонгон ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргаж сурна.

Үйл хэрэг болгох/хэрэгжүүлэх	12-р ангийн суралцагчтай ярилцлага хийх	Ярилцлага авах замаар ажил мэргэжил, түүнд шаардагдах ур чадвар, сонгон суралцах чиглэлийн талаар мэдлэгээ өргөжүүлнэ.	Суралцах чиглэл, ажил мэргэжилтэй холбоотой ярилцлага авч сурна. Бусдын туршлагыг судлан суралцах чиглэл, ажил, мэргэжлийн төлөвлөгөөгөө хэрхэн хэрэгжүүлэх арга барилд суралцана.
	Зочин		
Эргэж харж, дүгнэх	Бага анги	Сургалтын үр дүн болон явцаа эргэн харах, түүгээр дамжуулан өөрийнхөө талаар таньж мэднэ.	Өмнөх ангиудад судалсан хичээлийн сурлагын амжилтыг эргэн харж, дүгнэх
	8-р анги		8-р ангийн сурлагын амжилтаа өөрийн гаргасан ажил мэргэжлийн төлөвлөгөөтэйгээ уялдуулж сурна. Анхаарал хандуулж суралцахаар төлөвлөсөн хичээлүүддээ ахиц гаргахаар дахин төлөвлөнө.

### Үнэлгээ

8 дугаар ангийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хэрэгжилтэд багш суралцагчдын хийсэн төрөл бүрийн дасгал даалгаврын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх замаар үнэлгээ хийж болно.

Жишээ нь: “Миний мэргэжил, миний сонголт” сэдвээр зохион бичлэг бичүүлж, суралцагчдын ажил мэргэжлийн сэтгэлгээ, итгэл үнэмшил, хандлагыг илрүүлж болно.

### Фокус бүлгийн үнэлгээ

7-8 суралцагчтай бүлэг үүсгэж, багш өөрөө асуултуудаа боловсруулан өгч хэлэлцүүлэг хийлгэж болно. Суралцагчдын ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагаагаар олж авсан мэдлэгээ ашиглан өөрийн үзэл бодлоо илэрхийлж байгаа байдлаар нь тэдний суралцах чиглэл, ажил мэргэжлийн талаарх төсөөлөлажил мэргэжлийн сэтгэлгээ, хандлагын өөрчлөлтийг багш дүгнэж болно.

Асуултын жишээ:

- Ямар ажил мэргэжил сонгох хэрэгтэй талаар тодорхой бодол, санаа байна уу?
- Ирээдүйд ямар ажил хийхийг хүсч байна вэ?
- Өөрийн сонирхож хүссэн ажлаа хийхийн тулд ямар мэргэжилтэй болох вэ?
- Сонгосон мэргэжлийг эзэмшихийн тулд хаана сурч болох вэ?
- Ямар төрлийн ажил мэргэжил чамд тохирно гэж бодож байна вэ? Яагаад?
- Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхдээ юуг харгалзаж үзсэн бэ?
- Ажил мэргэжилтэй холбоотой мэдээллийг хаанаас олж авч байна вэ?

## **Ашиглах хэрэглэгдэхүүн, ном зүй (Цахим онлайн, ном гарын авлага)**

АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Багшийн гарын авлага /ЕБСийн 8,9 дүгээр ангийн багш нарт зориулсан гарын авлага/ 2016 он
- Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, 2016 он
- Эцэг эхэд зориулсан гарын авлага, 2016 он
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

### **Цахим эх сурвалж:**

- [www.myfuture.mn](http://www.myfuture.mn)
- [www.mergejil.mn](http://www.mergejil.mn)
- [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- [www.onisep.fr](http://www.onisep.fr)
- [www.myworldofwork.co.uk](http://www.myworldofwork.co.uk)
- [www.careers.govt.nz](http://www.careers.govt.nz)
- <https://myfuture.edu.au>
- <https://www.onetonline.org>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.